



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 5/06

Өмнөдэлгэр сум

Д.Шинэтуяаг ажилд томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1 дахь хэсэг, 139.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Номын санч Дагвасүрэнгийн Шинэтуяа нь жирэмсний болон амаржсаны амралтын хугацаагаа дуусгавар болгож ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажилд нь томилсугай.

2. Номын санч Д.Шинэтуяагийн албан тушаалын зэрэглэлийг ТҮСБ-3 буюу 1,414,000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга) төгрөг, орон нутгийн нэмэгдлийг 40 хувь, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцон бодож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг номын санч Д.Шинэтуяад үүрэг болгосугай.

ДАРГА



Т.МӨНХТӨР